

УРИЛГА

“МОНГОЛ УЛСЫН 10 АЙМГИЙН ТӨВИЙН ДУЛААН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БАЙГАА ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВД ДУЛААНЫ СТАНЦ БАРЬЖ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА, ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Эрхэм хүндэт,

Дундговь аймгийн төвийн ард иргэд, төрийн байгууллагууд, дулаан хангамжийн үйлчилгээ үзүүлж буй ААН компаниудын хамт олон та бүхнийг Эрчим хүчний Яам, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон зөвлөх БНСУ-ын “Ёошин” консорциум, “Эко Трейд” ХХК-ийн хамтран зохион байгуулж буй “Монгол улсын 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэж байгаа аймгийн төвд дулааны станц барьж ашиглах төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний танилцуулга, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хэлэлцүүлгийн зорилго: “Монгол улсын 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл” болон тус төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн талаарх мэдээллийг холбогдох талуудад түгээж, ил тод хүртээмжтэй болгох, хэлэлцүүлгээс гарсан саналыг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусган боловсруулах юм.

Хэлэлцүүлгийн оролцогчид: Эрчим хүчний яам, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эрчим хүч зохицуулах зөвлөл, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, БОАЖ газар, Ус цаг уур орчны шинжилгээний алба, Онцгой байдлын газар, Нэгдсэн үйлчилгээ хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах алба, сумын Засаг даргын Тамгын газар, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын багийн дарга нар, аймаг сумын түүх соёлын өв хариуцсан мэргэжилтэн, Дулаан хангамжийн үйлчилгээ эрхэлж буй байгууллага, компани, дулаан хангамжийн компанид ажилладаг нийт ажилчид, ТББ-ууд, Иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлүүд болон орон нутгийн бүх иргэд.

Хэлэлцүүлгийн байршил, огноо болон танхим

Хэлэлцүүлгийн байршил: Дундговь аймгийн Сайнцагаан сум Мандалговь хот

Хэлэлцүүлгийн танхим: Аймгийн ЗДТГ-ын 2-р давхрын том хурлын танхим

Хэлэлцүүлгийн огноо, цаг: 2019 оны 3-р сарын 18-нд 11:00 цагт

Хөтөлбөр

Үргэлжлэх хугацаа	Үйл ажиллагаа
11:00 – 11:10	Нээлтийн үг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн)
11:10 – 11:30	Илтгэл 1: Төслийн танилцуулга (Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир)
11:30 – 12:00	Илтгэл 2: Монгол улсын 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд хийгдэх “Дундговь” аймгийн төвд дулааны станц барьж ашиглах төслийн байгаль орчин, нийгмийн

	нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн үр дүнгийн танилцуулга (Эко Трейд ХХК)
12:00 – 12:40	Асуулт/Хариулт (төсөл хэрэгжүүлэх нэгж)
12:40 – 12:50	Төсөлд санал авах
12:50 – 13:00	Хаалтын үг (Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир)

Хэлэлцүүлгийн үеэр та бүхний хэлсэн үг, асуулт, саналуудыг бүрэн тэмдэглэж авах бөгөөд оновчтой саналуудыг Монгол улсын 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн БОННУ-ний тайланд тусгана. Та бүхний санал уг төсөл болон төслийн БОННУ-г илүү сайжруулахад хувь нэмэр оруулах тул төсөл болон уг төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний танилцуулгатай урьдчилан танилцаж, саналаа бэлтгэж ирэхийг хүсэж байна. Төслийн танилцуулгыг Фейсбүүк цахим хуудас www.facebook.com/DulaaniiStantsTusul, мөн цаасан хэлбэрээр аймгийн ЗДТГ-ын 305 тоотоос авах боломжтой.

Та бүхэн энэхүү төсөлтэй холбоотой урьдчилан бэлдсэн саналаа аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст болон доорх хаягуудаар цахим хэлбэрээр ирүүлэх боломжтой.

Хаяг	Аймгийн ЗДТГ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
Утас	70592150, 70593075, 70273911, 77060067, 99814947, 99011694, 99133434, 95089055
Фейсбүүк цахим хуудас	www.facebook.com/DulaaniiStantsTusul
Цахим шуудан	contact@ecotrade.mn

Жич: Та бүхэн санал, зөвлөмжөө илгээхдээ тухайн аймаг, сумын нэр болон өөрийн товч мэдээллээ бичиж илгээнэ үү.

Энэхүү олон нийтийн хэлэлцүүлэгт таны оролцоо болон санал маш чухал бөгөөд таныг идэвхтэй оролцоно гэдэгт найдаж байна.

Хүндэтгэсэн,

Төсөл хэрэгжүүлэгч: Эрчим Хүчний Яам

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний

олон улсын зөвлөх "Ёошин" консорциум, дотоодын зөвлөх "Эко Трейд" ХХК